

УИХ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА,
ГИШҮҮД БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ САЛБАРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА.

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, УИХ-ын гишүүн Н.Энхболд нар 2014 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах их сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа.

Байнгын хорооны дарга, гишүүдийг Батлан хамгаалах яамны дэд сайд Баттөр болон Батлан хамгаалахын сайдын зөвлөл, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын зөвлөлийн гишүүдтэй уулзлаа. Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Д.Баярсайхан Батлан хамгаалах яамны бүтэц, зохион байгуулалт болон салбарын үйл ажиллагааны талаар, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар тус тус танилцуулга хийлээ. Танилцуулгуудтай холбогдуулан Байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүдийн сонирхсон асуултад Батлан хамгаалахын сайдын зөвлөл, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын зөвлөлийн гишүүд хариулт өгч, батлан хамгаалах, зэвсэгт хүчний салбарын асуудлаар харилцан санал солилцов. Мөн Зэвсэгт хүчний жанжин штабын Ажиллагааны удирдлагын төв, Батлан хамгаалах их сургуулийн үйл ажиллагаатай танилцлав.

Зэвсэгт хүчний жанжин штабын даргын зөвлөлийн гишүүдтэй дурсгалын зураг авахуулж, Бүх цэргийн их хар сүлдний өргөөнд хүндэтгэл үзүүлээ.

Мэдээ бэлтгэсэн: АБГББХ-ны референт С.Эрдэнэчимэг